

БАТЛАВ.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХАВЭА-Н САЛБАР ХОРООНЫ ДАРГА
С.ЖАВХЛАНБААТАР

АТА14031 9129294
09.01.2010

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН
“ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙН САРЫН АЯН”-ЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Аж үйлдвэр, геологи, уул уурхай, газрын тосны салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг сайжруулах, салбарт ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг эрчимжүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ:

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй нийт аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогчид, ажилтан ажиллагсад.

Гурав. Хугацаа:

Сарын аян 2025 оны 4-5-р сард 1 сарын турш хугацаанд үргэлжилнэ.

Дөрөв. Аяны хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагууд нь Олон Улсын хөдөлмөрийн байгууллагаас 2025 онд дэвшиүүлсэн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил: Хиймэл оюун ухааны хэрэглээ ба цахимжилт” уриан дор сарын аяныг зохион байгуулах тухай удирдлагын шийдвэр гаргаж, холбогдох зардлыг төсөвлөх;
2. Уриатай уялдуулан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хяналтын болон гүйцэтгэлийн шинэлэг арга хэрэгсэл турших, аюул ослоос урьдчилан сэргийлэх, ажлын байрны хөдөлмөрийн болон ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг, ослын үеийн бэлэн байдлыг хангах, сайн дурын аврах эрэн хайх багийг бүрдүүлэх, чадавхижуулах,
4. Сарын аянд удирдлагын манлайллыг хангаж, ажилтан бүрийг оролцуулан, мэдлэг хандлага, соёлыг төлөвшүүлэх чиглэлээр нийт ажилтны мэдлэг, чадавхийг нэмэгдүүлэх, орон нутаг, иргэдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Тав. Аяныг дүгнэх, үр дүнг тооцох:

1. Аяны үр дүнг аж ахуйн нэгж байгууллага дотооддоо үнэлж, дүгнэн, идэвхитэй, үр бүтээлтэй оролцсон бүтэц, нэгж, ажилтныг урамшуулах;
2. Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг фото зураг, видео бичлэг, бусад хэлбэрээр баталгаажуулан АҮЭБЯ-ны ХАБЭА-н салбар хороонд ирүүлэх;
3. Аянд идэвхитэй оролцсон аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг яам, агентлагийн түвшинд дэмжин, хамтран ажиллах.

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ